ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АХГ-2022/02/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Сарансүх Утас: 264004 Цахим хаяг: saransukhya@audit.gov.mn Аудитын хоёрдугаар газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Эрдэнэзул Утас:261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn Аудитор: О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn Аудитор: М.Лхагвасүрэн Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ 4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан 6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан 10
3. Аудитын тайлан 11
3.1 Ерөнхий зүйл 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 12
3.4 Материаллаг байдал 12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга 12
3.5.1 Мөнгөн хөрөнгө 12
3.5.2 Авлага 13
3.5.3 Урьдчилгаа 13
3.5.4 Бусад эргэлтийн хөрөнгө 13
3.5.5 Үндсэн хөрөнгө 14
3.5.6 Өр төлбөр 14
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 15
3.6.1 Төсвийн төлөвлөлт 15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл 16
3.6.3 Нэмэлт төсөв 17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 17
3.8 Аудитын гол асуудал 18
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 19
4. Аудитын илрүүлэлт 21
4.1 Харьяа байгууллагууд 21
4.1.1 Төлбөрийн акт 21
4.1.2 Албан шаардлага 21
4.1.3 Зөвлөмж /түүврийн аудитаар/ 22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХХББАХЗ	Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.04.25 № 985
танай _____-ны № _____-т

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Б.МӨНХБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**534,480,024.6**	**673,356,963.9**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,482,525.8	70,842,728.1
33	АВЛАГА	157,907,025.5	192,340,738.5
34	УРЬДЧИЛГАА	14,490,898.4	7,194,964.2
35	БАРАА МАТЕРИАЛ	13,643,516.3	13,807,741.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	310,956,058.6	389,170,791.6
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**158,769,879.2**	**158,211,941.3**
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000.0	1,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	158,768,879.2	158,210,941.3
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**693,249,903.8**	**831,568,905.2**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**396,880,377.4**	**471,809,445.8**
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	99,885,950.5	157,721,366.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	296,994,426.8	314,088,078.9
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**296,369,526.4**	**359,759,459.4**
51	Засгийн газрын хувь оролцоо	296,369,526.4	359,759,459.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	2,470,083.1	2,470,083.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	8,247.3	8,247.3
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	212,479.8	212,479.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	73,152,925.9	73,152,925.9
51200	Хуримтлагдсан үр дүн	219,397,128.9	282,517,180.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,128,661.5	1,398,543.0
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**693,249,903.8**	**831,568,905.2**

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН**	**206,736,502.8**	**353,135,113.0**
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,302,028.0	82,202,721.6
120	Нийтлэг татварын бус орлого	100,302,028.0	82,202,721.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,434,474.8	270,932,391.4
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**54,075,019.8**	**173,181,522.9**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,075,019.8	173,181,522.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,644,762.9	35,848,044.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,092,633.9	4,449,726.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	520,435.0	578,497.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,634.0	238,548.3
2104	Хангамж, бараа материалын зардал	514,708.2	425,528.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,339.5	22,934.0
2107	Томилолт, зочны зардал	73,341.1	59,922.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,843,067.2	27,026,052.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,340,604.0	3,046,835.6
212	ТАТААС	0.0	120,124,001.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,430,256.9	17,209,476.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	152,661,483.0	179,953,590.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	838,362.8	1,123,676.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	57,221,197.0	32,281,519.7
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН**	**96,278,648.8**	**148,795,747.1**

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	**2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**264,027,816.9**	**-**	**264,027,816.9**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(63,977,187.4)	-	(63,977,187.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,050,629.5	-	200,050,629.5
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	40,248.2	-	40,248.2
9	Тайлант үеийн үр дүн	96,278,648.8	-	96,278,648.8
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,369,526.5	-	296,369,526.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(85,675,695.7)	-	(85,675,695.7)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	210,693,830.8	-	210,693,830.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	269,881.5	-	269,881.5
19	Тайлант үеийн үр дүн	148,795,747.1	-	148,795,747.1
20	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**359,759,459.4**	**-**	**359,759,459.4**

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН**	**142,639,819.7**	**334,061,384.4**
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,544,540.5	61,935,539.0
120	Нийтлэг татварын бус орлого	36,544,540.5	61,935,539.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	106,095,279.2	272,125,845.4
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**50,426,636.7**	**167,213,503.1**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,426,636.7	167,213,503.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,350,961.2	29,907,592.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,876,923.7	8,358,712.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,179,061.0	2,459,407.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,422.8	205,050.8
2104	Хангамж, бараа материалын зардал	10,554,366.4	8,890,154.3
2105	Норматив зардал	609.6	563.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,934.0	19,785.6
2107	Томилолт, зочны зардал	103,524.9	60,716.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,777,310.2	4,945,997.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,596,808.6	4,967,204.9
212	ТАТААС	0.0	120,123,247.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,075,675.5	17,182,663.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	92,213,183.0	166,847,881.3
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	476,284.2	210,219.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	77,878,369.6	129,279,394.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,878,369.6	129,279,394.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(77,402,085.4)	(129,069,175.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(5,394,342.6)	(4,418,503.9)
14	Бусад эх үүсвэр	9,016,355.1	7,772,161.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000.0	5,000,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	9,410,697.7	7,190,665.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	9,416,755.0	33,360,202.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,065,770.8	37,482,525.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,482,525.8	70,842,728.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**217,879,243,500.00**	**207,250,560,658.75**	**10,628,682,841.25**	**95.1**
III. УРСГАЛ ЗАРДАЛ	19,588,920,300.00	19,451,222,271.69	137,698,028.31	99.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,768,307,700.00	5,767,538,207.50	769,492.50	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,276,069,800.00	3,276,061,550.43	8,249.57	100.0
Үндсэн цалин	2,092,656,800.00	2,055,701,952.04	36,954,847.96	98.2
Нэмэгдэл	1,073,678,900.00	1,112,723,198.16	(39,044,298.16)	103.6
Унаа хоолны хөнгөлөлт	109,734,100.00	107,636,400.23	2,097,699.77	98.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	439,569,400.00	439,569,400.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	309,326,600.00	309,326,600.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	32,560,700.00	32,560,700.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	26,048,600.00	26,048,600.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	6,512,100.00	6,512,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	65,121,400.00	65,121,400.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,740,300.00	62,426,880.00	313,420.00	99.5
Байрны түрээс	62,740,300.00	62,426,880.00	313,420.00	99.5
Хангамж, бараа материалын зардал	84,269,200.00	84,105,671.50	163,528.50	99.8
Бичиг хэрэг	25,925,400.00	25,854,986.10	70,413.90	99.7
Тээвэр, шатахуун	21,218,000.00	21,207,550.00	10,450.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,582,700.00	18,622,636.40	(39,936.40)	100.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	174,300.00	94,400.00	79,900.00	54.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,368,800.00	18,326,099.00	42,701.00	99.8
Норматив зардал	567,700.00	563,414.00	4,286.00	99.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	567,700.00	563,414.00	4,286.00	99.2
Эд хогшил, урсгал засварын зардал	3,405,700.00	3,040,445.39	365,254.61	89.3
Багаж, техник, хэрэгсэл	1,376,600.00	1,294,645.39	81,954.61	94.0
Урсгал засвар	2,029,100.00	1,745,800.00	283,300.00	86.0
Томилолт, зочны зардал	14,967,200.00	14,742,486.00	224,714.00	98.5
Дотоод албан томилолт	14,967,200.00	14,742,486.00	224,714.00	98.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,870,795,600.00	1,871,120,928.18	(325,328.18)	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,624,037,800.00	1,625,901,818.54	(1,864,018.54)	100.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	765,000.00	225,000.00	77.3
Даатгалын үйлчилгээ	12,186,400.00	12,177,490.00	8,910.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	927,600.00	903,596.00	24,004.00	97.4
Тээврийн хэрэгслийн оношилгоо	557,100.00	553,600.00	3,500.00	99.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,218,100.00	16,090,393.64	127,706.36	99.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	215,878,600.00	214,729,030.00	1,149,570.00	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	15,922,800.00	15,907,432.00	15,368.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	15,922,800.00	15,907,432.00	15,368.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,820,612,600.00	13,683,684,064.19	136,928,535.81	99.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,506,290,700.00	13,370,209,341.89	136,081,358.11	99.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,504,379,600.00	13,368,298,241.89	136,081,358.11	99.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911,100.00	1,911,100.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	314,321,900.00	313,474,722.30	847,177.70	99.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,631,900.00	32,384,800.00	247,100.00	99.2

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	190,200,000.00	189,600,000.00	600,000.00	99.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,490,000.00	91,489,922.30	77.70	100.0
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	193,290,323,200.00	182,799,338,387.06	10,490,984,812.94	94.6
Барилга байгууламж	164,998,823,200.00	156,182,848,690.06	8,815,974,509.94	94.7
Их засвар	24,851,500,000.00	23,244,437,997.00	1,607,062,003.00	93.5
Тоног төхөөрөмж	3,440,000,000.00	3,372,051,700.00	67,948,300.00	98.0
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	5,000,000,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**217,879,243,500.00**	**207,250,560,658.75**	**10,628,682,841.25**	**95.1**
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	217,729,243,500.00	207,100,560,658.75	10,628,682,841.25	95.1
Улсын төсвөөс санхүүжих	217,729,243,500.00	207,100,560,658.75	10,628,682,841.25	95.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	150,000,000.00	150,000,000.00	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.00	150,000,000.00	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	164	164		100.0
Удирдах ажилтан	13	17		130.7
Гүйцэтгэх ажилтан	145	147		101.4
Гэрээт ажилтан	6	-		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл		52,483.1
ОРЛОГЫН ДҮН		**2,963,424.0**
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		912.302.4
ЗГНХ,ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		922,959.2
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		543,787.9
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		584,374.5
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		**2,906,341.2**
А.УРСГАЛ ЗАРДАЛ		2,747,706.5
1.БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,307,603.7
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		141,790.9
Үндсэн цалин		141,090.9
Нэмэгдэл		700.0
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		16,176.1
Тэтгэврийн даатгал		12,860.1
Тэтгэмжийн даатгал		829.0
ҮОМШӨ-ний даатгал		663.2
Ажилгүйдлийн даатгал		165.8
Эрүүл мэндийн даатгал		1,658.0
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		2,149,636.7
Бичиг хэрэг		1,089.2
Тээвэр, шатахуун		1,710.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		865.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		552.2
Багаж, техник, хэрэгсэл		86,298.0
Тавилга		27,806.0
Дотоод албан томилолт		2,798.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		609,044.6
Бараа үйлчилгээний бусад зардал		1,419,473.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		440,102.8
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		351,037.2
Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		89,065.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		158,634.7
Дотоод эх үүсвэрээр		158,634.7
Их засвар		158,634.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		57,082.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		109,565.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд аудитын түүвэрт хамрагдсан зарим байгууллагад төсвийг зориулалтын дагуу зарцуулах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, дээд шатны эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн сүлжээ, хэмжээг үндэслэн ажиллагсдын үндсэн цалинг тогтоож байх зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын аудитор О.Баярмаа, аудитор М.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1439 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Барилга, хот байгуулалтын яам нь эрхэм зорилгоо “Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн, барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн, нийтийн аж ахуй, орон сууцны, инженерийн дэд бүтцийн салбаруудын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Барилгын салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 39 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай” 234 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд ерөнхий материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт зардал 212,879.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,128.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт зардлын үзүүлэлтээр тооцоолсныг гүйцэтгэлийн үе шатанд дахин хянаж, өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,320.4 сая төгрөгөөр буюу 19.9 хувиар нэмэгдсэн байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 37,482.5 сая, эцсийн үлдэгдэл 70,842.7 сая төгрөг болж, 33,360.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	5.3	9.7	4.5
Төрийн сангийн харилцах	19,980.0	44,501.8	24,521.8
Арилжааны банк дахь төгрөгийн харилцах	17,169.7	25,965.3	8,795.7
Нэмэлт санхүүжилтийн харилцах	52.5	108.4	55.9
Арилжааны банк дахь валютын харилцах	275.0	257.3	(17.7)
Дүн	37,482.5	70,842.7	33,360.2

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 33,360.2 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолоор БХБЯ-ны хөрөнгө оруулалтын зарцуулаагүй 29,345.2 сая төгрөгийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, БХТ ТӨААТҮГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БХБЯ, БШУЯ, ЭМЯ-дын захиалгаар баригдаж байгаа барилга, байгууламжид захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн нь нөлөөлжээ.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 157,907.0 сая, эцсийн үлдэгдэл 192,340.7 сая төгрөг болж, 34,433.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой авлага	9.6	13.7	4.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	806.4	790.7	(15.7)
Татаас, санхүүжилтийн авлага	673.3	0.0	(673.3)
Дансны авлага /ТӨҮГ/	155,218.5	158,186.3	2,967.8
Бусад авлага	1,199.3	33,350.0	32,150.7
Дүн	157,907.0	192,340.7	34,433.7

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өссөн нь төрөөс хариуцан төлөх цэвэр бохир усны үйлчилгээний төлбөрийн 25,282.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, мөн нэр бүхий 93 аж ахуйн нэгж, байгууллагад 7,529.1 сая төгрөгийн усны төлбөрийн хөнгөлөлтийг илүү олгож авлагад бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- ТОСК ТӨХХК: Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд байрлах 20 айлын орон сууцны түрээслэгчдээс авах 74.8 сая төгрөгийн авлагыг түрээслэгчидтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй гэсэн үндэслэлээр бүртгэлд тусгаагүй, /2021 онд түрээслэгчдээс авах авлагын үлдэгдлийг бүртгэлд залруулж оруулсан/
- ТОСК ТӨХХК: Санхүүгийн тайлангийн аудитаар 2017 онд өгсөн зөвлөмжийн дагуу 23.5 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээс 15.4 сая төгрөгийг төлүүлээгүй,
- БХБЯ ТШЗ: Тайлант оны эцэст ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 1.7 сая төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэж, урьдчилж гарсан зардалд бүртгэсэн, мөн хувь хүний орлогын албан татварт 1.8 сая төгрөгийг дутуу шилжүүлэн өглөг үүсгэсэн зэрэг зөрчил илэрсэн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 14,490.9 сая, эцсийн үлдэгдэл 7,195.0 сая төгрөг болж, 7,295.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	14,490.9	7,195.0	(7,295.9)
ДҮН	14,490.9	7,195.0	(7,295.9)

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурсан нь БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн ажлын гүйцэтгэлээр бусад эргэлтийн хөрөнгөд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

3.5.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 310,956.1 сая, эцсийн үлдэгдэл 389,170.8 сая төгрөг болж, 78,214.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	203,524.3	291,722.5	88,198.2
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	107,431.8	97,448.3	(9,983.5)
Дүн	310,956.1	389,170.8	78,214.7

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 78,214.7 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийг барьж дуусах хүртэл эргэлтийн хөрөнгөд бүртгэсэнтэй холбоотой байна.

Мөн Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Буянт-Ухаа-2 хорооллын байр болон гражийг борлуулснаас эргэлтийн хөрөнгө буурсан байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн цэвэр дүнгийн эхний үлдэгдэл 167,353.7 сая, эцсийн үлдэгдэл 169,137.8 сая төгрөг болж, 1,784.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	80,182.2	80,853.1	670.9
Авто-тээврийн хэрэгсэл	2,355.0	2,491.9	136.9
Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,424.7	5,788.4	363.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,067.6	1,197.2	129.7
Бусад үндсэн хөрөнгө	41.8	44.4	2.6
Дуусаагүй барилга, байгууламж	9,606.5	9,606.5	-
Биет бус хөрөнгө	68,256.7	68,767.3	510.6
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	419.3	389.0	(30.3)
Дүн	167,353.7	169,137.8	1,784.1

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өсөхөд ХСУХАТАҮЗЗ сургалт, судалгааны төвийн зориулалтаар худалдан авсан 2 үл хөдлөх хөрөнгийг, БХТ ТӨААТҮГ нь ТӨБЗГ-ын 2021 оны 605 дугаар тогтоолын дагуу “Барилгын мэдээллийн нэгдсэн сангийн програм”-ыг тус тус үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- ХСУХАТАҮЗЗ: Тус зөвлөл нь сургалт, судалгааны төвийн зориулалтаар 230 м2 байрыг 290.7 сая, 231 м2 байрыг 380.2 сая, нийт 670.9 сая төгрөгийн 2 үл хөдлөх хөрөнгийг худалдан авсан боловч улсын бүртгэлийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй.
- ТОСК ТӨХХК: Зарим сумдад 40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд барьсан, бүртгэлд байгаа 4 болон 8 айлын 108 ширхэг чанарын шаардлага хангаагүй орон сууцны үнэ цэнийн бууралтыг бүртгэх нөхцөл үүссэн боловч холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй.
- ХХББАХЗ: Тайлант онд ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй урсгал зардлаас 37.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
- ГЗБГЗЗГ: Тайлант онд гүйцэтгэсэн "ОХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутгаар дайран өнгөрөх хий дамжуулах хоолойн трассын нутаг дэвсгэрийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх төсөл"-өөс тухайн ажилд хамааралгүй өрөөний засварын зардалд 22.0 сая төгрөгийг зарцуулж, 31.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, мөн төсвийн хөрөнгөөр 12.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
- БХТ ТӨААТҮГ: Үндсэн хөрөнгийн дансанд 109 нэр төрлийн 20.4 сая төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгө бүртгэсэн.
- БХБЯ ТШЗ: Тус яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 0453УБҮ улсын дугаартай Hyunday sonata-7 маркийн автомашиныг 2021 оны 12 сараас БХТ ТӨААТҮГ-т ашиглуулж байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 396,880.4 сая, эцсийн үлдэгдэл 471,809.4 сая төгрөг болж, 74,929.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	99,886.0	157,721.3	57,835.3
Өглөг	82,445.0	139,314.7	56,869.7
Урьдчилж орсон орлого	17,440.9	18,406.6	965.7
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	296,994.4	314,088.1	17,093.7
Урт хугацаат зээл	296,994.4	314,088.1	17,093.7

Дүн	396,880.4	471,809.4	74,929.0

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдэл өссөн нь тус яамны хөрөнгө оруулалтын зарим санхүүжилтийн үлдэгдлийг тайлант оны эцэст барьцааны өглөгийн дансанд шилжүүлсэн, мөн төрөөс хариуцан төлөх цэвэр бохир усны үйлчилгээний төлбөрийн санхүүжилтийг дутуу олгосон, зарим аж ахуйн нэгж, байгууллагад усны төлбөрийн хөнгөлөлтийг илүү тооцож олгосонтой холбоотой 69 аж ахуйн нэгж, байгууллагад 32,582.5 сая төгрөгийн өглөг үүссэн зэргээс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өссөн нь Сангийн яамнаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу ТОСК ТӨХХК-д 5,000.0 сая төгрөгийн зээл олгосон, ТОСК ТӨХХК-ийн Буянт-Ухаа 1, Буянт-Ухаа 2 хорооллын бүтээн байгуулалтад авсан зээлийн хүү, Сангийн яамнаас авсан өмнөх зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн зээлийн хүүг хуримтлуулан тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 296,369.5 сая, эцсийн үлдэгдэл 359,759.4 сая төгрөг болж, 63,389.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	75,843.7	75,843.7	-
Хуримтлагдсан үр дүн	219,397.1	282,517.2	63,120.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,128.7	1,398.5	269.8
Дүн	296,369.5	359,759.4	63,389.9

Эх сурвалж: БХБЯ-ны 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 148,795.7 сая төгрөгийн үйл ажиллагааны үр дүнтэй ажилласантай холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 1,398.5 сая төгрөг болж 269.8 сая төгрөгөөр өссөн нь БХТ ТӨААТҮГ нь тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрлөөр дахин үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын бичилт нь БХБЯ-ны өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээний 80,241.3 сая, ТОСК ТӨХХК-аас Засгийн газрын 2021 оны 120 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийн 4,154.5 сая, зээлийн хүүгийн зөрүүгийн 1,175.8 сая, маргаан таслах торгууль, татварын алданги, Эрүүгийн цагдаагийн шинжилгээний төлбөрийн 46.7 сая, БХТ ТӨААТҮГ-ын өмнөх оны ногдол ашгийн төлбөр 105.7 сая төгрөг зэрэг нийт 85,724.0 сая төгрөгөөр бууруулан, БХТ ТӨААТҮГ-ын ААНОАТ-ын өмнөх жилүүдийн зөрүү 48.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тус тус өмнөх үеийн үр дүнд өөрчлөлт оруулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 514,341.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, төслийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 225,038.4 сая төгрөгөөр баталснаас 2021 оны төсвийн тухай

хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 7,159.2 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар бууруулан 217,879.2 сая төгрөгөөр тодотгон батлагдсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх нийт 6 хөтөлбөрийн 268 төсөл, арга хэмжээнд зориулан 217,879.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 193,290.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 13,504.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгт, 5,000.0 сая төгрөгийг дамжуулан зээлийн төлбөрт, 6,084.5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 204,224.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 13,504,4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 150.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 193,732.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 13,368.3 сая, нийт 207,100.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 150.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 207,250.5 сая төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь цар тахлын улмаас зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт дутуу гүйцэтгэлтэй, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үе шатны ажлын гүйцэтгэлээр олгосон зэрэгтэй холбоотой ба тусгай зориулалтын шилжүүлгийн болон урсгал зардлын зарцуулаагүй үлдэгдэл нийт 137.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 181 төсөл, арга хэмжээнд 193,290.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр 178 төсөл арга хэмжээнд 182,799.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, үлдэгдэл 1.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн, он дамжин хэрэгжүүлэх 44 төсөл, арга хэмжээний 29,345.2 сая төгрөгийг барьцааны дансанд шилжүүлсэн байна. Мөн орон нутагт хэрэгжүүлэх 60,703.7 сая төгрөгийн 92 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл */сая төгрөг/*

№	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71509	Барилга, хот байгуулалт, НАА-н бодлого, удирдлага	217,879.2	207,250.5	10,628.7	95.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,768.3	5,767.5	0.8	99.9
1.2	80502	Тусгай зориулалтын шилжүүлэг	13,506.3	13,370.2	136.1	99.0
1.3	80704	Алдар цолтой ахмадын тэтгэмж	190.2	189.6	0.6	99.7
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	124.1	123.9	0.2	99.8
1.5	80918	Хөрөнгө оруулалт	193,290.3	182,799.3	10,491.0	94.6
1.6	83117	Орон сууцжуулах	5,000.0	5,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт

- ХСУХАТАҮЗЗ: Тайлант онд нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний баярыг тохиолдуулан шагналд 8.1 сая, бэлэг дурсгал, мэндчилгээнд 4.0 сая, баримтат кинонд 8.0 сая, тэмдгийн төлбөрт 4.0 сая төгрөг, ном худалдан авахад 7.9 сая, нийт 32.0 сая төгрөгийг зарцуулсан,
- ТОСК ТӨХХК: Захирлын тушаалаар мөнгөн тусламжийг хавтгайруулан 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 10 хүнд олгосон, хөдөлмөрийн дотоод журамд заасныг зөрчин 7 хүнд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 22.1 сая төгрөгөөр илүү олгосон,
- БХТ ТӨААТҮГ: Батлагдсан төсвөөс спортын уралдаан тэмцээний зардалд 11.5 сая төгрөгийг зарцуулсан, мөн автомашины 100 км-т зарцуулах шатахууны батлагдсан жишиг нормыг мөрдөөгүйгээс 15.6 сая төгрөгийг илүү зарцуулсан.
- ГЗБГЗЗГ: Газрын кадастрын зураглал хэвлэх үнэт цаасны тендерт Монголын үнэт цаас хэвлэл ХХК шалгарч, нэгжийн үнийг 220.00 төгрөгөөр тогтоон гэрээ байгуулсан боловч нэмэлт гэрээ байгуулан нэгж бүтээгдэхүүнийг 485.00 төгрөгөөр худалдан авч 5.3 сая төгрөгийг илүү төлсөн,

- ХХББАХЗ: Эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн сангийн хэмжээг үндэслээгүй, захиргааны даргын тушаалаар ажиллагсдын үндсэн цалинг 2.5-4.5 сая төгрөгөөр тогтоож олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц хөрөнгөөс 922.9 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 782.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 673.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 584.4 сая, нийт 2,963.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 158.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2,149.6 сая, хөрөнгийн зардалд 158.6 сая, нийт 2,466.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 440.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төрийн орон сууцны корпораци ТӨХХК нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийн 36,190,047.00 ам.долларын, зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн орон сууцны төслийн зээлийн 142,693.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2013 оны 263 дугаар тогтоолын дагуу “Төрийн орон сууцны корпораци”-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах 100.0 сая хүртэл ам.доллартай тэнцэх хөрөнгийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан 2013 онд санхүүжүүлэх арга хэмжээ авахыг зөвшөөрсний дагуу 2013.09.30-ны өдөр З-ОС-Б 2013-166 дугаар зээлийн гэрээг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-тай байгуулж, “Буянт-Ухаа I орон сууцны хороолол” төслийн 1575 айлын орон сууцны хороллын 25 барилгын ажлын санхүүжилтэд 20,000.0 сая төгрөгийн зээлийг, жилийн 9.8 хувийн хүүтэй олгосон ба зээлийн гэрээнд 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, нийт 1764 айлын орон сууцны хороллын 28 барилгын ажлын санхүүжилтэд нийт 84,700.0 сая төгрөгийн зээлийг 7.0 хувийн хүүтэй олгосон байна.

Хөгжлийн банктай 2021.12.31-ний өдрийн байдлаар 69,105.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2. Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолын дагуу Төрийн орон сууцны корпорацийн захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан, төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 929 айлын орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээлийн төлбөрт шаардагдах 52,058.9 сая төгрөгийг 2017, 2018, 2019 оны улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусгаж шийдвэрлэх, зээлийн төлбөрийг бүрэн төлж барагдуулах хүртэлх хугацаанд зээлийн хүүгийн төлбөрийг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 929 айлын орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хөгжлийн банк нь Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-тай 2015.06.08-ны өдөр З-ОС-Б 2015-34 дүгээр зээлийн гэрээг байгуулж “Буянт-Ухаа II орон сууцны хороолол” төслийн санхүүжилтэд 35,505,413.10 ам.долларын зээлийг, жилийн 7.0 хувийн хүүтэй олгосон ба зээлийн гэрээнд 2019.12.30-нд нэмэлт өөрчлөлт оруулж, валютын зээлийн үлдэгдлийг төгрөгт хөрвүүлэн 83,587.8 сая төгрөг болсон байна.

Хөгжлийн банктай 2021.12.31-ний өдрийн байдлаар 73,587.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

3. Засгийн газрын 2015 оны 117 дугаар тогтоолын дагуу “Шинэ яармаг” орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 50.0 сая.ам доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-аар дамжуулан санхүүжүүлэх эрх олгосны дагуу Хөгжлийн банкнаас 2015.05.28-ны өдөр З-ОС-Б 2015-33 дугаар зээлийн

гэрээг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-тай байгуулж, төсөл хэрэгжүүлэгч Нью яармаг хаусинг прожект ХХК-д 50.0 сая ам.долларыг, жилийн 8.45 хувийн хүүтэй зээлийг дамжуулан олгосон байна.

Хөгжлийн банктай 2021.12.31-ний өдрийн байдлаар 29,134,792.00 ам.доллар буюу 82,999.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

4. Засгийн газрын 2015 оны 462 дугаар тогтоолын дагуу Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨҮГ-ын худалдан авах “UBM” барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборын санхүүжилтэд шаардагдах 9,686,846.00 ам.долларын эх үүсвэрийн 85.0 хувьд Хөгжлийн банкны баталгаа гаргаж, АНУ-ын Экспорт, Импорт банкны эх үүсвэрээс, үлдэх 15.0 хувьд зохих журмын дагуу Засгийн газрын өрийн баталгааг гарган Хөгжлийн банкны эх үүсвэрээс тус тус санхүүжүүлэх арга хэмжээ авч, гэрээ байгуулж ажиллах зөвшөөрөл олгож, зээлийн эргэн төлөлтөд шаардагдах хөрөнгийг 2017-2019 оны улсын төсвийн төсөлд үе шаттайгаар хэсэгчлэн тусгах арга хэмжээ авахыг даалгасан байна.

Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолын дагуу Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-ын худалдан авах “UBM” барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборын санхүүжилтэд шаардагдах 8,300,300.00 ам.долларын 85.0 хувь болох 7,055,255.00 ам.долларыг АНУ-ын Экспорт, Импорт банкнаас зээл авах хүртэлх хугацаанд зохих журмын дагуу Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлэхээр шийдвэрлэн, үлдэгдэл 1,245,045.00 ам.доллар, уг тоног төхөөрөмжийг импортоор авахад шаардагдах нэмэлт болон үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэхийг даалгасан ба энэ тогтоол гарсантай холбогдуулан 2015 оны 462 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байна.

Хөгжлийн банктай 2021.12.31-ний өдрийн байдлаар 7,055,255.00 ам.доллар буюу 20,099.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Барилга, хот байгуулалтын сайдын 2021 онд хэрэгжүүлэх төсөв, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 52 зорилтын 303 арга хэмжээг нийт 94.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн ба 3 арга хэмжээний гүйцэтгэл зорилтот түвшинд хүрээгүй байна. Тухайлбал:

1. Лаг хатаах, шатаах байгууламжийн “Техникийн ерөнхий шаардлага, стандарт”-ыг Японы ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавх бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулахаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх;
2. Салбарын мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлдэг МСҮТ-ийн дадлага олгох нэгдсэн материаллаг баазыг бүсчлэн байгуулах судалгаа хийх;
3. Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчныг бүрдүүлж, улсын хэмжээнд байгаа түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажил эхлүүлэх;

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан харьяа 6 байгууллагаас ариутгалын бодис, хамгаалалтын материалд 86.6 сая, ариутгалын хаалга, шүүгээ худалдан авахад 11.2 сая, ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн төлбөрт 16.5 сая, нийт 100.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын дагуу www.shilendans.gov.mn цахим хуудсанд төсөв захирагч мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 492 мэдээллээс 490 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт

- БХТ ТӨААТҮГ: Шилэн дансны цахим хуудсанд нийт 13,735.5 сая төгрөгийн ажил, гүйлгээний 22 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,
- ХСУХАТАҮЗЗ: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 161.1 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мөн гүйлгээ бүрийн анхан шатны баримт болон холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй,
- БХБЯ ТШЗ: Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 28.1 сая, зарлагын 33.5 сая, нийт 61.6 сая төгрөгийн 9 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны худалдан авах ажиллагааны төсөвт тусган Чингэлтэй дүүргийн 46 айл өрхийн дээвэр, ханын дулаалгад 2,769.3 сая төгрөгийн ажил, мөн дүүргийн зарим айлуудын хашаан дотор 500.0 сая төгрөгийн эко жорлон барих ажлыг гүйцэтгүүлсэн зэрэг нийт 3,269.3 сая төгрөгийн зарцуулалт нь тухайн жилийн бодлогын чиглэлд туссан нэн тэргүүний ач холбогдолтой эсэх нь тодорхойгүй, цөөн айлуудыг хамруулан, хувийн орон сууцанд хийсэн, хөрөнгийг бүртгэлд тусгах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 7.3-т "Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл арга хэмжээнд дараах шаардлагыг тавина", 7.3.2-т "төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, журамд заасныг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 234.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, Хөгжлийн банкны санхүүжилтээр 2014-2017 онд "Дэд бүтэц төсөл"-ийн хүрээнд хэрэгжүүлсэн дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 9,606.5 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээг бүрэн дуусгаж, хөрөнгийн өмчлөлийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 70.0 хувьтай байна.

Хүснэгт 10. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт */сая төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	234.4	1	187.5			80.0
Зөвлөмж	2	-	1	-	1	-	85.0
Нийт дүн	3	234.4	1	187.5	1	-	82.5

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус яамны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын 2019 оны 430, 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдаж, гэрээ байгуулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн

санхүүжилтийн үлдэгдлийг шилжүүлэн байршуулж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон боловч тайлант оны эцэст 2019 оны 562.9 сая, 2020 оны 711.5 сая, нийт 1,274.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй 7 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3-т тусгасан “Хөшигийн хөндийд шинэ хотууд болон эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх” ажлын хүрээнд ХХББАХЗ-ны статусыг тодорхой болгож, Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 11 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн санхүүгийн тайланд тус тус “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 1,966.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 2,128.8 сая төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

4.1 Харьяа байгууллагууд

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,008.5 сая төгрөгийн 32 алдаа, зөрчлийг илрүүлснээс 200.7 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 22.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,349.9 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 435.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 158.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 135.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 23.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 37.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1.1 Төлбөрийн акт

1. Тус яамны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд хуримтлагдсан 8-аас дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн 19 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 135.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь</u>: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

4.1.2 Албан шаардлага

1. Барилга байгууламжийн норм, нормативын сангийн авлагын дансанд бүртгэлтэй, 5-аас дээш жилийн насжилттай 23.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх ... ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь</u>: Дээрх зөрчлийг арилгаж, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, холбогдох хуульд заасныг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх

2. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,008.5 сая төгрөгийн 32 алдаа, зөрчлийг илрүүлснээс 200.7 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 22.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,349.9 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага,

435.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, албан шаардлага өгөх

4.1.3 Зөвлөмж /түүврийн аудитаар/

1. Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа нь тайлант онд ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй урсгал зардлаас 37.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ", 14.2.2 "улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах", 14.2.4 "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах ... саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасныг зөрчсөн байна.

> Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх

2. Эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн сүлжээ, хэмжээг үндэслээгүй захиргааны даргын тушаалаар ажиллагсдын үндсэн цалинг 2,500.0-4,500.0 мянган төгрөгөөр тогтоож, олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн сүлжээ, хэмжээг үндэслэн цалинг тогтоох, холбогдох Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
										Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР АСУУДЛААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ																
Төсвийн ерөнхийлөн захирагч																	
1	Барилга, хот байгуулалтын сайд	1	1					3	158.9			1	135.6	2	23.3		
	Дүн	1	1					3	158.9			1	135.6	2	23.3		
Төсвийн төвлөрүүлэн захирагч																	
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1	1					5	81.2					4	81.2	1	-
	Дүн	1	1					5	81.2					4	81.2	1	-
Төрийн өмчит үйлдвэрийн газар																	
3	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	1	1					4	56.8					3	36.5	1	20.3
4	ТОСК ТӨХХК	1		1				14	1,113.6	3	187.8	1	22.1	7	525.7	3	378.0
5	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл	1		1				4	714.9	1	11.9			3	703.0		
	Дүн	3	1	2				22	1,885.3	4	199.7	1	22.1	13	1,265.2	4	398.3
Төсөл хөтөлбөрийн нэгж																	
6	Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ төсөл	1					1										
7	Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл	1					1										
8	Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны төсөл	1					1										
	Дүн	3					3										
Төсвийн шууд захирагч																	

9	Барилга, хот байгуулалтын яам	1	1					3	4.5	1	1.0			1	3.5	1	-
10	БХБЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар	1					1										
11	Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа	1					1	2	37.5							2	37.5
Дүн		**3**	**1**				**2**	**5**	**42.0**	**1**	**1.0**			**1**	**3.5**	**3**	**37.5**
НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН		**11**	**4**	**2**			**5**	**35**	**2,167.4**	**5**	**200.7**	**2**	**157.7**	**20**	**1,373.2**	**8**	**435.8**

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН НИЙЦЛИЙН АСУУДЛААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ											
Төсвийн ерөнхийлөн захирагч											
1	Барилга, хот байгуулалтын сайд	1	-					1	-		
Дүн		1	-					1	-		
Төрийн өмчит үйлдвэрийн газар, зөвлөл											
2	Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ	1	13,735.5							1	13,735.5
3	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл	1	161.6					1	161.6		
Дүн		2	13,897.1					1	161.6	1	13,735.5
Төсвийн шууд захирагч											
4	Барилга, хот байгуулалтын яам	1	61.6							1	61.6
Дүн		**1**	**61.6**							**1**	**61.6**
НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН		**4**	**13,958.7**					**2**	**161.6**	**2**	**13,797.1**

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 2025 № 863/А01/0001 Улаанбаатар хот

АКГ-2022/021НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,008.5 сая төгрөгийн 32 алдаа, зөрчлийг илрүүлснээс 200.7 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 22.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,349.9 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 435.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Ганхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

2022 оны 04 дугаар сарын 25 № 160/A0150053 Улаанбаатар хот

АХГ-2022/21/ЧА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны их засвар, хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд хуримтлагдсан 8-аас дээш жилийн насжилттай, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн 19 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 135,618,374.78 төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2 "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн 19 аж ахуйн нэгж, байгууллагын барьцааны үлдэгдэл, нийт 135,618,374.78 төгрөг (нэг зуун гучин таван сая зургаан зуун арван найман мянга гурван зуун далан дөрвөн төгрөг далан найман мөнгө)-г Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Должинсүрэн нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
9019120399

0001090380

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын ____ № 824/А0170066 Улаанбаатар хот
АХГ-2022/21/НА-СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны их засвар, хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төсөвт тусган Чингэлтэй дүүргийн 46 айл өрхийн дээвэр, ханын дулаалгад 2,769,293,574.00 төгрөгийн ажил, мөн дүүргийн зэрим айлуудын хашаан дотор 500,000,000.00 төгрөгийн эко жорлон барих ажлыг гүйцэтгүүлсэн зэрэг нийт 3,269,293,574.00 төгрөгийн зарцуулалт нь тухайн жилийн бодлогын чиглэлд тусан нэн тэргүүний ач холбогдолтой эсэх нь тодорхойгүй, цөөн айлуудыг хамруулан, хувийн орон сууцанд хийсэн, хөрөнгийг бүртгэлд тусгах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 7.3 "Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл арга хэмжээнд дараах шаардлагыг тавина", 7.3.2 "төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Должинсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР О.БАЯРМАА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0425 Auditin 2 Gazar-32.Docx

0001082090

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 25 № 825/А0170066 Улаанбаатар хот
АХГ-2022/18/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барилга байгууламжийн норм, нормативын сангийн авлагын дансанд бүртгэлтэй, 5-аас дээш жилийн насжилттай 23,275,520.00 төгрөгийн авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх ... ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Должинсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР О.БАЯРМАА

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0425 Auditin 2 Gazar-31.Docx

0001082088